



ОНЦГОЙ БАЙДЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
АЛБАН ДААЛГАВАР

2026 оны 01 сарын 26 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг
сахиулах зарим арга хэмжээний тухай

Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Онцгой байдлын байгууллагын "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм"-ийн хэрэгжилтийг хангуулах, "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежментийн тогтолцоо-Шаардлага, хэрэглэх заавар" MNS ISO 45001:2018 стандартыг хэрэгжүүлэх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл, салбар зөвлөлийн ажлыг эрчимжүүлэн тогтвортой үйл ажиллагааг хангах, алба хаагчдын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг мөрдүүлэх зорилгоор төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын дарга, захирагч нарт ДААЛГАХ нь:

1. Дарга, захирагч нар Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 28.1.7-д заасны дагуу ажил олгогчийн сургалтад бүрэн хамрагдсан байх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиг, үүргийг нэгжийн удирдлагын түвшинд хэрэгжүүлж ажиллах;

2. Харьяа болон төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын салбар, нэгжийн хэмжээнд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хэрэгжилтэд дотоод хяналт, шалгалт, үзлэг зохион байгуулж, илэрсэн зөрчил, эрсдэлийг бууруулах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж, үр дүнг тайлагнах;

3. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үйл ажиллагаанд шаардагдах зардлыг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2-д заасны дагуу (*Төсвийн байгууллага нь тухайн жилийн батлагдсан төсвийн 0.5 хувиас, аж ахуйн нэгж, байгууллага эрсдэлийн түвшнээс хамааран үйлдвэрлэл, үйлчилгээний зардлын 1.5 хувиас доошгүй хэмжээний хөрөнгийг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд тус тус зарцуулна*) зориулалтын дагуу үр ашигтай зарцуулж, баримтжуулан тайлагнах;

4. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орон тооны бус зөвлөлийн үйл ажиллагааг идэвхжүүлж, улирал тутам үнэлгээ хийж, үр дүнд тулгуурласан арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

5. Ажлын байрны эрсдэлийн үнэлгээг тогтмол хийж, эрсдэлийг ноцтой, өндөр, дунд, бага гэж ангилан, эрсдэлийн сан үүсгэж, бууруулах арга хэмжээг төлөвлөж, хэрэгжилтэд хяналт тавих;

6. Шинээр томилогдсон (үйлдвэрлэлийн дадлагын сонсогч, албан тушаал өөрчлөгдсөн) болон нийт алба хаагчдыг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл, ахуйн сургалт, дадлагад бүрэн хамруулж, мэдлэг, дадал, хэвшлийг баталгаажуулах, хяналт, шалгалтыг тогтмолжуулах, шаардлагатай тохиолдолд давтан сургалт зохион байгуулж, хяналтын хуудсаар баталгаажуулах;

1426020002

7. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого болон осол дөхсөн тохиолдлыг бүртгэж, шалтгааныг мэргэжлийн түвшинд судлан дүгнэж, дахин гарахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх, хэрэгжилтийн явцыг тухай бүр тогтмол мэдээлэх;

8. Жолооч бүрэлдэхүүний мэргэжлийн ур чадварыг тогтмол дээшлүүлэх, автомашины техникийн бүрэн бүтэн байдлыг хангах, ээлжийн жолооч бэлэн байлгах, GPS, хурд, маршрутын хяналтыг хэрэгжүүлэх, жолоочийн хөдөлмөр, амралтын горимыг зохицуулж, тэмдэглэл хөтлүүлэх, хариуцсан албан тушаалтан хэрэгжилтэд хяналт тавих;

9. ОБЕГ-ын даргын 2025 оны А/475 дугаар тушаалаар батлагдсан “Амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажиллах үед дагаж мөрдөх дүрэм”-ийн дагуу бүсийн төвүүд, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын амьсгалын бие даасан төхөөрөмжийн засвар үйлчилгээний төв, засварын хэсгийг шаардлага хангасан өрөө, тасалгаанд байрлуулж, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг бүрдүүлэн, ашиглалтад оруулах;

10. Амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажиллах дадлага, сургалтыг мэргэжлийн өндөр түвшинд зохион байгуулах зорилгоор тусгай тоноглол бүхий талбай, утаатай болон давчуу орчинд ажиллах сургалтын байгууламжийг тохижуулан бэлтгэх;

11. Ажлын тусгай хамгаалах хувцас, хэрэгслийн бүртгэл, хадгалалт, халдваргүйтгэл, засвар үйлчилгээг холбогдох стандарт, дүрэм, журмын дагуу мөрдүүлж, актлах журмыг хэрэгжүүлж, хяналтын тогтолцоог бүрдүүлэх, хамгаалах хувцас, хэрэгслийн чанар, эдэлгээний хугацаанд тогтмол хяналт тавих, Мөн алба хаагчдыг хамгаалах хэрэгслийг бодит нөхцөлд зөв ашиглах сургалт, дадлагад тогтмол зохион байгуулж, ур чадварыг баталгаажуулах;

12. Алба хаагчдыг эрүүл мэндийн урьдчилсан болон хугацаат үзлэгт бүрэн хамруулж, мэргэжлээс шалтгаалах өвчний илрүүлэг, тандалтыг сайжруулах, үзлэгийн дүнг эрүүл мэндийг дэмжих арга хэмжээнд ашиглах, томилгоот бүрэлдэхүүний эрүүл мэнд, сэтгэл зүйг үнэлж, өдөр тутмын үзлэг, хяналтыг тогтмол хийж, бүртгэл хөтлөн, эрсдэлийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх;

13. Алба хаагчдын сэтгэл зүйн байдлыг үнэлж, гамшиг, осол, гал түймэр, аврах ажиллагааны дараах сэтгэл зүйн зөвлөгөө, ярилцлагыг тогтмолжуулж, сэтгэл зүйн эрсдэлийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх;

14. Хоол үйлдвэрлэл, ундны усны эрүүл ахуйн шаардлагыг хангаж, холбогдох хууль, стандартын хэрэгжилтэд тогтмол хяналт тавих, эрүүл, зохистой хооллолтын чанар, аюулгүй байдлыг сайжруулах арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлэх;

Албан даалгаврын хүрээнд зохион байгуулсан ажлын тайланг заалт тус бүрээр гаргаж, гүйцэтгэсэн ажлын хүснэгтийн хамт, хавсралтад заасан шалгуур үзүүлэлтийн дагуу тооцож, хагас жилийн тайланг 2025 оны 06 дугаар сарын 03, жилийн эцсийн тайланг 11 дүгээр сарын 06-ны өдрийн дотор тус тус ирүүлэхийг нийт дарга, захирагч нарт, биелэлтийн үр дүнг нэгтгэж, танилцуулахыг Гамшгаас хамгаалах сургалтын газрын дарга, хурандаа Х.Сүхбаатарт, албан даалгаврын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дэд дарга, хурандаа Ц.Уранчимэгт тус тус даалгав.

ДАРГА,
ХОШУУЧ ГЕНЕРАЛ



Г.АРИУНБУЯН

Онцгой байдлын ерөнхий газрын даргын
2026 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн
01 дүгээр албан даалгаврын хавсралт

ЖИН (АЧ ХОЛБОГДОЛ), ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

№	Албан даалгаврын агуулга	Шалгуур үзүүлэлт (KPI)	Жин (ач холбогдол)
1	ХАБЭА ажил олгогчийн сургалт	- Дарга, захирагчдын сургалтад хамрагдсан баталгаажилт	4
2	Дотоод хяналт, шалгалт	- Жилийн төлөвлөгөө батлагдсан - Хяналт шалгалт ≥ 1 удаа/улирал тутам - Илэрсэн зөрчлийн $\geq 80\%$ арилгасан	10
3	ХАБЭА-д зарцуулах санхүүжилт	- Хуулиар заасан 0.5% / $\geq 1.5\%$ санхүүжилт бүрэн тусгагдсан - Зардал 26.5-д заасан арга хэмжээнд зарцуулагдсан - Санхүүгийн тайлан, нотлох баримт бүрдсэн	5
4	ХАБЭА-ын зөвлөлийн үйл ажиллагаа	- Зөвлөл улирал тутам хуралдсан (≥ 4 удаа) - Аян ≥ 4 - Хурлын тэмдэглэл, шийдвэр гарсан - Шийдвэрийн хэрэгжилт $\geq 70\%$	10
5	Ажлын байрны эрсдэлийн үнэлгээ	- Эрсдэлийн үнэлгээ 100% хийгдсэн - Эрсдэлийг 4 түвшинд ангилсан - Эрсдэлийн сан - Ноцтой, өндөр эрсдэлийг бууруулах төлөвлөгөөний хэрэгжилт	10
6	Ослын бүртгэл, судалгаа	- Ослын болон осол дөхсөн тохиолдол бүртгэгдсэн - Шалтгааны дүн шинжилгээ хийсэн - Дахин давтагдсан осол нэмэгдээгүй	10
7	Жолоочийн тээврийн хяналт	- Жолооч нарын сургалт ≥ 4 улирал тутам - Тээврийн хэрэгслийн үзлэг 100% - GPS, хурд, маршрутын хяналт хэрэгжсэн - Ээлжийн жолооч	5
8	Сургалт, дадлага	- ХАБЭА-ын анхан шатны сургалт 100% - Үнэлгээ хийгдсэн байдал - Давтан сургалт - Зааварчилгааны хяналтын хуудас	5
9	АББТ засвар үйлчилгээ	- Засварын төв/хэсэг дүрмийн шаардлага хангасан - Тоног төхөөрөмж бүрэн $\geq 70\%$	6
10	АББТ дадлага сургалт	- Тусгай сургалтын талбай - Утаатай, давчуу орчны сургалт зохион байгуулсан - Сургалтад хамрагдалт $\geq 80\%$	10
11	Тусгай хамгаалах хувцас, хэрэгсэл	- Бүртгэл, хадгалалт - Хэрэглээний зөрчил буурсан хувь - Халдваргүйтгэл, актлалт хийгдсэн - Ашиглалтын сургалт тогтмол	10
12	Эрүүл мэндийн үзлэг	- Урьдчилсан, хугацаат үзлэгт хамрагдалт $\geq 95\%$ - МШӨ-ний тандалт хийгдсэн - Өвчлөлтэй буурсан хувь	5

13	Сэтгэлзүйн эрүүл мэнд	- Алба хаагчдын $\geq 80\%$ нь улирал тутмын сэтгэлзүйн үнэлгээнд хамрагдсан - Гамшиг, ослын дуудлагад үүрэг гүйцэтгэсэн алба хаагчдын $\geq 90\%$ нь анхан шатны дэмжлэг авсан - Өндөр эрсдэлтэй алба хаагчдын хувь $\geq 10\%$ буурсан эсвэл тогтвортой - Сэтгэлзүйн шалтгаант сахилгын зөрчил нэмэгдээгүй - Үр дүнг төвлөрсөн бүртгэл, тайланд нэгтгэсэн	5
14	Хоол, ундны усны эрүүл ахуй	- Эрүүл ахуйн хяналт ≥ 1 удаа/улирал - Усны Зөрчил илрээгүй эсвэл бүрэн сайжруулсан - Хоолны чанарын сэтгэл ханамж сайжирсан - Хүнснээс шалтгаалах хордлого < 0	5
			100

Жич: Албан даалгаврын хүрээнд хийж гүйцэтгэсэн ажлын мэдээг <https://forms.gle/gHZ3GqYPPA4g8BnQ7> линкээр бөглөж, тоон мэдээллээс бусад ажлын тайланг MsWord үйлдлийн систем дээр хийж, тайланг obeg.habea@gmail.com хаягаар ирүүлэх.

Холбогдох мэдээллийг Гамшгаас хамгаалах сургалтын газрын Бие бүрэлдэхүүний сургалт, хөдөлмөрийн аюулгүй байдлын хэлтсээс тодруулах.
Утас: 51263000.

---oOo---